



НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 18 өдөр

Дугаар 19/37

Улаанбаатар хот

「 Хүмүүнлэгийн тусламж үзүүлэх тухай 」

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.6, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Хөгжлийн хамтын ажиллагааны тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Турк улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн 1 дүгээр зүйл, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Бүгд Найрамдах Турк улсад тохиолдсон байгалийн гамшигт нэрвэгдэгсдэд хүмүүнлэгийн тусламж үзүүлэх ажлыг зохион байгуулахыг Засаг даргын Тамгын газар (Л.Санжийжамц)-д үүрэг болгосугай.

2.Тусламжид шаардагдах хөрөнгийн төсвийг хавсралтаар баталсугай.

3.Тусламжид шаардагдах 3,500,000 (Гурван сая таван зуун мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцон ажиллаж, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчлан ажиллахыг Засаг даргын эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч (Б.Болормаа)-д даалгасугай

ЗАСАГ ДАРГА  А.СҮХБОЛД



AJIL2023 он ажилгэвхирамж

1123000109

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2023 оны 02 сарын 13-ны өдрийн 1/37 дугаар
захирамжийн хавсралт



ТУСЛАМЖИД ШААРДАГДАХ ХӨРӨНГИЙН
ТӨСӨВ

№	Хэрэглэгдэхүүн	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Иж бүрэн 5 ханатай гэр	ширхэг	1	3,500,000	3,500,000
		Нийт дүн			3,500,000